



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/31

Амардалай

Төлбөр тооцоо гүйцэтгэх эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралтын 7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 1000 801 55405 тоот "Байгаль хамгаалах сан", 1000 801 55407 тоот "Мал хамгаалах сан"-гийн бүртгэлийн дансуудад хяналт тавьж, зарлагын гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх баримтанд 1 дүгээр гарын үсэг зурах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Нарантунгалаг), 2 дугаар гарын үсэг зурах эрхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) нарт түр хугацаагаар олгосугай.

2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг Төсвийн шууд захирагч (С.Нарантунгалаг), нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАЯРСҮХ